



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №31



2018 оны 9-р сарын 03-07

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1204** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 105(8.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1072(89%) хачигт халдвар, 12(1.0%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1072** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.2%-иар бага байна. Эпидемиологийн 35-р долоо хоногтой харьцуулахад 20 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



Хачигт риккетсиозын 796 сэжигтэй тохиолдлын 185(23.2%), хачигт энцефалитын 183 сэжигтэй тохиолдлын 32(17.5%), хачигт боррелиозын 93 сэжигтэй тохиолдлын 24(25.8%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 129 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **105** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12%-иар бага байна. Эпидемиологийн 35-р долоо хоногтой эрсдэлд өртсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.




1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Өмнөговь аймгийн Манлай суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 61 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 11.5%-иар их байна. Эпидемиологийн 35-р долоо хоногтой харьцуулахад 22.2%-иар бага үзүүлэлттэй байна.



Энэ 7 хоногт СХД, БЗД, БЗД, БГД-ээс ирүүлсэн амьтны (тарвага 29 ширхэг) дуудлагад үйлчилж, хураагдсан сорьцыг ЗӨСҮТ-ийн лабораторит шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Шүлхий өвчин

Төв аймгийн Алтанбулаг сумын Алтан-Овоо багийн “Мандал” гэдэг газар 8-р сарын 31-нд малчин 2 өрх айлын 13 үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч УМЭАЦТЛ-т шинжлүүлэхэд 9-р сарын 03-ны өдрийн шинжилгээний хариугаар шүлхий өвчин болох нь тогтоогдсон. Тус суманд 9-р сарын 02-нд хорио цээрийн дэглэм тогтоож, голомтод нутгийн 2 өрх айлын 18 малыг устгаж, 1600 бог малыг вакцинжуулан ажилласан байна.

Эх сурвалж: ОБЕГ

Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:


Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын харьяат “Э” нь 37 настай, эрэгтэй. 9-р сарын 01-ний өдөр Төмөрбулаг сум Тал булаг гэдэг газар малчин айлд тарваганы мах идсэн. Аймаг руугаа буцах замдаа Бүрэнтогтох сумын “Цагаан бургасын даваа” гэдэг газар тарвага цохиж алсан. Тарвагыг оролдоогүй, хаясан. 9-р сарын 03-наас 40.1 хэм хүртэл халуурч НЭ-ийн 103-т очиж чих хамар хоолойн эмчид үзүүлсэн. Улмаар 9-р сарын 04-ний 13:00 цагт Далайн-Элбэрэл өрхийн ЭМТ-д үзүүлэн, 14:00 цагт дахин аймгийн НЭ-т үзүүлэн тусгаарлагдан хэвтсэн байна. Хэвтэх үедээ зүүн суганы булчирхай цочсон, хэл өнгөртэй, хоолой улайлттай, толгой өвдөх, хоолонд дургүй, чичрүүлэх, ядрах, ам цанган гэсэн зовиуртай. 9-р сарын 05-ны аймгийн ЗӨСТ-ийн лабораторийн ийлдэс судлалын шинжилгээгээр тарваган тахал төст савханцар харагдаагүй байна.

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн ЗӨСТ

Олон улсад:

Эбола вирус халдвар:


БНАК улсад 8-р сарын 31-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 116 сэжигтэй 86 батлагдсан, 30 болзошгүй) тохиолдол, үүнээс 77 нас баралт мэдээлэгдээд байна. Тус мужуудад эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн ажиллаж байна.



Эх сурвалж: ДЭМБ

Хонины цэцэг өвчин:

ОХУ-ын Москва мужид Каприпокс вирусээр үүсгэгдсэн хонины цэцэг өвчин бүртгэгдэж, 18 хонь өртсөнөөс, 5 нь өвчилж, 1 хонь өвчилж үхсэн. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

БНХАУ-ын Анхуй, Heilongjiang мужуудад гахайн аж ахуйд африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 546 гахай өртсөнөөс, 224 нь өвчилж, 92 гахай өвчилж үхэн, 454 гахайг устгасан байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Тайваны Юнлин мужийн шувуун аж ахуйд шувууны томуугийн H5N2 вирус халдварын дэгдэлт бүртгэгдэж, 28716 шувуу өртсөнөөс, 6380 шувуу өвчилж үхэн, 22336 шувууг устгасан. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Мал, амьтны галзуу өвчин:

Малайз улсын Сарабак хотын Кучинг мужид мал, амьтны галзуу өвчний улмаас, 483 нохой өртсөнөөс, 1 нохой өвчилж, 38 нохойг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

Герман улсын Висмар хотын Mecklenburg-Vorpommern мужид шувууны томуугийн Н5И6 вирүст халдварын дэгдэлт бүртгэгдэж, 133 шувуу өртсөнөөс, 16 нь өвчилж, 14 шувуу өвчилж үхэн, 119 шувууг устгасан. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалт судалгааг эрчимжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баян-Өлгий, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Завхан, Дундговь, Өмнөговь аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн. Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?